

# Судалгааны Тойм

№12 | WWW.FORUM.MN | БОДЛОГЫН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ | СУДАЛГААНЫ САН | ВИДЕО

## ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГА: ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭ-2017

### ТОВЧ ТАЙЛБАР

Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолоор баталсан “Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын шалгуур”, Хууль зүйн сайдын 2014 оны а/01 дүгээр тушаалаар баталсан “Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал”-ын дагуу Цагдаагийн ерөнхий газар Хэрэглэгчийн үнэлгээний тайланг жил бүр гаргах үүрэг хүлээсэн.

2012-2016 онд Цагдаагийн ерөнхий газар дээрх тайланг таван удаа гаргасан бөгөөд судалгааны дүнгээр иргэдийн сэтгэл ханамж жилээс жилд дээшилж байгаа гэж дүгнэжээ. Харин

хөндлөнгийн байгууллагын судалгаа олон нийт ялангуяа гэмт хэрэг, зөрчлийн улмаас хохирсон иргэд цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд төдийлөн сэтгэл ханамжгүй байгааг дурджээ. Тиймээс Нээлттэй Нийгэм Форумын захиалгаар Дотоод хэргийн их сургууль, Хөдөө аж ахуйн их сургуулийн судлаачдын баг “Цагдаагийн байгууллагын хэрэглэгчийн үнэлгээ” судалгааг хийлээ. Энэхүү тойм нь дээрх судалгаанд тулгуурласан бөгөөд уг тоймоор судалгааны гол үр дүн, санал, зөвлөмжийг уншигчдад хүргэхийг зорилоо. Судалгааг бүрэн эхээр нь [www.forum.mn](http://www.forum.mn) сайтаас татаж үзнэ үү.

### СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Судалгаанд хэрэглэсэн асуулгыг олон улсад түгээмэл хэрэглэгддэг аргачлалд тулгуурлан боловсруулсан. Энэ аргачлалыг Америкийн Нэгдсэн Улсын зарим муж, Их Британи Өмнөд Ирландын Нэгдсэн Вант Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Канад, Япон, Бүгд Найрамдах Солонгос Улс болон ардчилал

шинээр тогтсон улс орнуудын цагдаагийн албаны шинэчлэлийг үнэлэх зорилгоор ашигладаг. Судалгаанд оролцогчдыг иргэд, алба хаагч, хамтран ажилладаг байгууллага гэсэн 3 бүлэгт хувааж, нийслэлийн 6 дүүрэг, 21 аймгийн нийт 810 иргэн, 402 алба хаагч, 10 байгууллагын 291 төлөөллийг оролцууллаа.

## СУДАЛГААНЫ ДҮН

### Нэг. Иргэдийн сэтгэл ханамж

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг 5 бүлэгт багтах 32 асуултаар үнэлсэн бөгөөд нийт 5.0 үнэлгээ авахаас 3.25 авсан нь дундаж үзүүлэлт юм. Нийтдээ 8 аймаг, 6 дүүрэг улсын дунджаас дээгүүр үнэлгээ авсан бол 13 аймаг дунджаас доогуур үнэлгээ авчээ. Тухайлбал, Улаанбаатар хотын хэмжээнд хамгийн өндөр үнэлгээг Сүхбаатар дүүрэг, орон нутгаас Хэнтий аймаг авсан бол Баянзүрх дүүрэг, Булган аймаг хамгийн бага үнэлгээг авчээ. Улсын хэмжээнд сайнаас (4.0) дээш үнэлгээ авсан цагдаагийн газар, нэгж байхгүй байгаа нь төдийлөн сайн үзүүлэлт биш юм.

1. *Цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн үнэлгээ:* Цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүрэгт хамаарах гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажлыг иргэд дунд зэрэг (3.4) гэж үнэлжээ. Иргэдийн зүгээс цагдаагийн байгууллага нь нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргээ сайн биелүүлдэг (3.4-3.8) гэж үзсэн бол, гэмт хэрэгтэй тэмцэх ажилд дунджаас доогуур үнэлгээ өгчээ. Тухайлбал, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг олж тогтоох, баривчлах ажилд төдийлөн сэтгэл ханамжгүй (2.99-3.1) байна.
2. *Хууль ёсны зарчмын хэрэгжилт:* Хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим бөгөөд иргэд уг зарчмын хэрэгжилтийг дунд зэрэг (3.11) гэж үнэлжээ. Тодруулбал, гэмт хэргийн талаар дуудлага, мэдээлэл өгсөн тохиолдолд түргэн шуурхай тусламж үзүүлдэг боловч асуудлыг хуулийн дагуу шуурхай шийддэггүй, мөн авилгаас ангид, шударга ажиллаж чаддаггүй, хүний эрхийн талаарх мэдлэг хангалтгүй гэжээ.

Түүнчлэн цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны ил тод, эргэлзээгүй байдалд иргэд сэтгэл ханамжгүй (2.99) байдаг нь анхаарал татсан.

3. *Орон нутгийн аюулгүй байдал:* Иргэдийн аюулгүй, тайван амьдрах нөхцөл нь орон нутгийн нөхцөл байдлаас хамаардаг тул орон нутгийн нөхцөл байдал тааламжгүй байх нь нийгмийн хэв журам зөрчигдөх, гэмт хэрэг үйлдэгдэх таатай нөхцөл болж, иргэдийн аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлдэг. Судалгаанд оролцогчид оршин суугаа нутаг дэвсгэрийнхээ аюулгүй байдалд сэтгэл ханамж дунд зэрэг (3.08) байдаг гэж хариулжээ. Үүнээс гудамж талбай, нийтийн эзэмшлийн газар бүрэн камержуулалтын системд холбогдож миний аюулгүй байдал хангагдсан (2.69), оршин суугчдын чөлөөт цагаа өнгөрүүлэх газар хангалттай байдаг (2.67) гэсэн асуултад иргэд сэтгэл ханамжгүй байгаагаа илэрхийлжээ. Харин авто замын нөхцөл байдал, гэрлэн дохио, замын тэмдэглэгээ сайн хийгдсэн гэдэгтэй 62.3 хувь нь санал нийлжээ.
4. *Алба хаагчийн ёс зүй:* Алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшилтөд (2.96) иргэд сэтгэл ханамжгүй байна. Ялангуяа, дээрх үзүүлэлт орон нутгийн иргэдийн хувьд тулгамдсан асуудал гэж үзжээ. Мөн цагдаагийн алба хаагчаас мэдээлэл авах, харилцан ойлголцоход хүндрэлтэй байдаг (3.1) талаар дурджээ. Цагдаагийн алба хаагч олон нийтийн газар биеэ зөв авч явж, бусдад үлгэр дуурайлал үзүүлдэг гэсэн үзүүлэлт хамгийн өндөр (3.2) үнэлгээ авчээ.
5. *Гэмт хэргээс түгших хандлага:* Гэмт хэргээс түгших мэдрэмж өндөр байх тусам цагдааг үнэлэх иргэдийн сэтгэл ханамж буурдаг. Судалгаанд оролцогчдын 71.9 хувь нь өөрөө

болон ойр дотнын хүмүүс нь гэмт хэрэг, халдлагад өртөж болзошгүй талаар түгшдэг гэжээ. Тухайлбал, миний хүүхэд, гэр бүлийн гишүүд гэртээ оройтож ирэх замдаа гэмт хэрэг, халдлагад өртөж болзошгүй гэж 83.7 хувь, олон нийтийн газарт мөнгө эд зүйл, авч явах үедээ хулгайд алдаж болзошгүй гэж 80.3 хувь, оршин суугаа газартаа шөнийн цагаар ганцаараа алхах үедээ айдастай байдаг гэж 70.7 хувь нь тус тус хариулжээ.

### **Хоёр. Алба хаагчдын сэтгэл ханамж**

Цагдаагийн алба хаагчдын ажлын байран дахь сэтгэл ханамжийг 7 бүлгийн 28 асуултаар үнэлэхэд ерөнхий дундаж 5 байхаас 3.52 үнэлгээ авсан нь алба хаагчдын сэтгэл ханамж дунд зэрэг байгааг харуулж байна. Улсын хэмжээнд 21 аймаг, 6 дүүргийн 402 алба хаагч судалгаанд оролцсон бөгөөд улсын дунджаас (3.52) дээгүүр үнэлгээг 11 аймаг, доогуур үнэлгээг 10 аймаг, 6 дүүрэг авчээ. Өөрөөр хэлбэл, нийт алба хаагчдын 36 хувь нь албандаа сэтгэл ханамжгүй буюу 2.90 гэсэн үнэлгээ өгсөн, 64 хувь нь дундаас дээш сэтгэл ханамжтай байгаагаа илэрхийлжээ. Сэтгэл ханамжийн дундаж үнэлгээгээр жагсаавал нэгдүгээрт Архангай, хоёрдугаарт Баянхонгор, гуравдугаарт Увс аймгууд тус тус орсон байна.

Цагдаагийн алба хаагчид цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүрэгт 46.0 хувь, хууль ёсны байдалд 55.9 хувь, хүний нөөцийн бодлогод 58.9 хувь, байгууллагын соёл, алба хаагчийн ёс зүйд 52.4 хувь, удирдлагын манлайлалд 56.0 хувь, алба хаагчийн нийгмийн баталгаанд 39.1 хувь сэтгэл ханамжтай гэжээ. Дээрх 6 үзүүлэлтийн дундаж нь 51.3 хувь байгаагаас үзэхэд алба хаагчид өөрсдийн нийгмийн баталгаанд сэтгэл дундуур хэдий ч албандаа хүндэтгэлтэй байдгийг харуулж байна. Цагдаагийн алба хаагчдын ажлын байрандаа сэтгэл ханамжгүй байх гол хүчин зүйлс нь орон тоо дутмаг, ажлын ачаалал их (2.44), цалин хөлс хангалтгүй (2.39), үүрэг гүйцэтгэх эдийн

засгийн баталгаа хангагдаагүй (2.62) гэдэгтэй 4 бүс, Улаанбаатар хотын алба хаагчид санал нэгдэж байна.

Цагдаагийн байгууллагын хүний нөөцийн бодлого, удирдлагын манлайллын талаарх сэтгэл ханамж улсын хэмжээнд дундаж үзүүлэлттэй гарсан ч Улаанбаатар хотын алба хаагчид сэтгэл ханамж доогуур байна. Тухайлбал, албан тушаал дэвших бололцоог жигд олгодоггүй, томилогдсон ажилд нь тогтвор суурьшилтай ажиллуулдаггүй, шагнах, урамшуулах болон хариуцлага тооцох тогтолцоо оновчтой биш, шударга бус байдаг гэж тэд үзжээ.

Цагдаагийн алба хаагчийн ажилдаа сэтгэл хангалуун байдаг шалтгааныг нээлттэй асуулгаар авахад нэр хүндтэй албаараа бахархдаг гэж 47 хувь; ард иргэдийг амгалан тайван байлгах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх гэж 18.9 хувь; гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх үед албаараа бахархдаг гэж 15.7 хувь; баталгаатай, тохилог ажлын байртай гэж 7.5 хувь; хувцас хэрэгсэл, хангамж олгодог гэж 5.7 хувь; хамт олны уур амьсгал сайтай гэж 5.0 хувь нь тус тус нэрлэжээ. Харин албандаа сэтгэл хангалуун бус байх хүчин зүйлсийг тодруулахад цалин хөлс бага, нийгмийн баталгаа хангалтгүй гэж 28.9 хувь; ажлын ачаалал, стресс ихтэй, орон тоо хүрэлцээгүй гэж 22.2 хувь; илүү цагаар, цалин хөлсгүй их ажилладаг, ар гэртээ цаг зарцуулах боломжгүй гэж 19.0 хувь; машин, техник хэрэгсэл дутагдалтай, чанаргүй хувцас, хэрэгсэлтэй, хангамж муу гэж 15.1 хувь; улс төрийн болон дээд албан тушаалтны зүгээс хууль бус шийдвэр гаргуулах тохиолдол байдаг гэж 8.8 хувь; торгуулийн хуудсаар шахах, шаардлагагүй бичиг цаасны ажил ихтэй гэж 5.9 хувь тус тус хариулжээ.

### **Гурав. Хамтран ажилладаг байгууллагын үнэлгээ**

Цагдаагийн байгууллагатай хамтран ажилладаг нийт байгууллагаас хамтран ажиллахад хялбар,

эсвэл хүндрэлтэй гэх 332 санал ирүүлэв. Үүнээс хамгийн олон давталттай эерэг санал нь цагдаагийн байгууллагатай хамтран ажиллахад шуурхай, итгэлтэй, хариуцлагатай, хялбар байдаг гэж 108 санал (35.6 хувь), хамгийн олон давтагдсан сөрөг саналд ёс зүй, харилцаа хандлага доголдолтой, дээрэнгүй, соёлгүй, албан

тушаалаар ялгаж харьцдаг, чирэгдэл учруулдаг, хүнд сурталтай, хэрэг шийдэхэд удаан, албан бичгийн хариуг хугацаанд нь өгдөггүй, албан хаагчид нь хуулийн мэдлэг дутуу, ур чадвар муу, ажлын ачаалал их, орон тоог нэмэх хэрэгтэй гэсэн асуудлууд багтсан байна.

## ЗӨВЛӨМЖ

1. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг ил тод, эргэлзээгүй, иргэдэд нээлттэй болгох үүднээс мэдээллийн жагсаалт гаргаж, сурталчлах ажлыг зохион байгуулах;
2. Цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшил, хүний эрхийн мэдлэг ур чадварыг сайжруулах нэгдсэн сургалт, соёл-олон нийтийн арга хэмжээг тогтмол зохион байгуулах, ялангуяа хөдөө орон нутгийн алба хаагчдад зориулсан тусгай төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх;
3. Хэрэглэгчийн үнэлгээнд гарч байгаа өөрчлөлтөд дүн шинжилгээ хийж, үр дүнг хариуцлага хүлээлгэх, урамшуулах тогтолцоонд харгалздаг болох;
4. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах, бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох, хүний нөөцийн бодлогыг гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдалтай уялдуулах;
5. Цагдаагийн албаны тухай хуулийн 87 дугаар зүйлийн 87.9 дэх хэсэгт заасан цагдаагийн алба хаагчийн үндсэн цалин, цолны цалин болон бусад нэмэгдлийн хувь хэмжээг нэмэх замаар шүүх, прокурор, авлигатай тэмцэх байгууллага зэрэг ижил чиг үүрэгтэй байгууллагын алба хаагчдын жишигт ойртуулан нэмэгдүүлэх, холбогдох байгууллагад уламжлах, шийдвэрлүүлэх;
6. Цагдаагийн алба хаагч үүрэг гүйцэтгэхэд шаардлагатай эдийн засгийн болон техник хэрэгслээр хангах хуульд туссан баталгааг эдлүүлэх;
7. Цагдаагийн байгууллагын алба хаагчдын стресс, сэтгэл гутралын түвшнийг тогтоож, түүнийг даван туулах арга зам, ач холбогдол, урьдчилан сэргийлэх талаар сургалт, зөвлөх үйлчилгээг сэтгэл зүйчдээр тогтмол явуулж байх;
8. Алба хаагч гэр бүлдээ зарцуулах болон өөрийгөө хөгжүүлэх цаг, бололцоогоор хангах бодлого, хөтөлбөр хэрэгжүүлэх.

### СУДЛААЧИД:

Б.Энхболд, Хууль зүйн ухааны доктор (Ph.D), дэд профессор, ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхимийн эрхлэгч

П.Мөнхтуяа, доктор, ХААИС, Эдийн засаг, Бизнесийн сургуулийн Эдийн засгийн статистик, математик загварчлалын тэнхимийн эрхлэгч

Г.Золзаяа, доктор (Ph.D), ХААИС, Эдийн засаг, Бизнесийн сургуулийн Эдийн засгийн статистик, математик загварчлалын тэнхимийн ахлах багш

Ш.Баярдulam, магистр (MSc), ХААИС, Эдийн засаг, Бизнесийн сургуулийн Эдийн засгийн статистик, математик загварчлалын тэнхимийн багш

### СУДАЛГААНЫ ТОЙМ БОЛОВСРУУЛСАН:

Б.Энхболд, Хууль зүйн ухааны доктор (Ph.D), дэд профессор, ХЭҮК-ын гишүүн

### САНАЛ, ШҮҮМЖ ӨГСӨН:

ННФ-ын Хуулийн хөтөлбөрийн менежер, Б.Хишигсайхан

